



**НИЙСЛЭЛИЙН  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Тооллогын комисс байгуулах  
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 70.2.1, 70.2.2, 71 дүгээр зүйлийн 71.1, 72 дугаар зүйлийн 72.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.2.1, 12.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. 2021 оны хагас жилийн мэдээ, тайлан гаргахтай холбогдуулан байгууллагын эд хөрөнгөд эхний хагас жилийн байдлаар тооллого явуулах комиссыг хавсралтын дагуу баталсугай.

2. Тооллогын бэлтгэл ажлыг ханган хуваарь гарган батлуулж, хуваарийн дагуу 2021 оны 06 дугаар сарын 16-наас 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрүүдэд зохион байгуулж дуусган, тооллогын дүнг 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулахыг комиссын дарга (Б.Галмандах), Ерөнхий нягтлан бодогч (Х.Цогзолмаа) нарт тус тус даалгасугай.


3. Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах, агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэл хөтлөлт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажиллахыг комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



ХЭРДЭНЭБИЛЭГ

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын  
даргын 2021 оны 28 дугаар сарын 11-ны  
өдрийн 28 дугаар тушаалын хавсралт



Комиссын дарга:

Б.Галмандах  
Орлогч дарга

Гишүүд:

Б.Ичинноров  
Сантехникийн инженер

М.Мөнхцэцэг  
Байр хариуцсан менежер

Ц.Өнөрбилэг  
Байр хариуцсан менежер

Д.Болормаа  
Зоогийн газрын менежер

Нарийн бичиг:

Г.Халиунаа  
Тооцооны нягтлан бодогч